## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН НИЙГМИЙН БАТАЛГАА, СУРГАЛТ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

***2024.05.15*** ***Шивээговь сум***

| Д/д | Тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ | Хүрэх үр дүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжүүлэх хугацаа | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| ***Зорилт 1: Төрийн албан хаагчийн цалин хөлс, нөхөх төлбөр, тусламж, шагнал урамшууллыг хууль тогтоомжийн дагуу олгох*** | | | | | | |
| 1. | Төрийн албан хаагчийн цалин хөлс, нэмэгдэл хөлс, нөхөх төлбөр, тусламж дэмжлэгийг холбогдох хууль журам, байгууллагын дотоод журмын дагуу тухай бүр шийдвэрлэж байх. | -Хуулийн дагуу албан хаагчдын цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлсийг бүрэн олгосон байна. | Холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэсэн байдал | I-IV улиралд | Аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/31 дүгээр захирамжийн дагуу сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн А/04 дүгээр ***"Төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгох тухай"*** тушаалаар сумын ЗДТГ-ын төрийн захиргааны албан хаагчдад 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутгийн нэмэгдлийг олгож эхлээд байна. Мөн Аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн Б/21 дүгээр захирамжийн дагуу сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/14 дүгээр "Албан хаагчдын цалинг шинэчлэн батлах тухай" тушаалаар сумын ЗДТГ-ын ***төрийн захиргааны, төрийн үйлчилгээний, гэрээт албан хаагчдын цалинг шинэчлэн*** батлаад байна. | 100% |

Scanned with CamScanner

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2. | Гэр хороололд амьдарч байгаа ажилтан, албан хаагчдад түлээ, нүүрсний тусламж үзүүлэх | - Гэр хороололд амьдарч байгаа ажилтан, албан хаагчдын судалгааг гаргасан байна.<br>- Гэр хороололд амьдарч байгаа ажилтан, албан хаагчдад түлээ, нүүрсийг олгосон байна. | Гэр хороололд амьдарч байгаа ажилтан, албан хаагчдын тоо<br>Гэр хороололд амьдарч байгаа ажилтан, албан хаагчдад түлээ, нүүрсийг олгох | I-IV улиралд | 2023 оны 11 дүгээр сард гэр хороололд амьдарч байгаа албан хаагчдын судалгааг гаргасан бөгөөд судалгаагаар 2 албан хаагч гэр хороололд амьдарч байна. 2024 оны 01 дүгээр сард тус 2 албан хаагчид байгууллагын "Дотоод журам"-ын 21.5-т заасны дагуу 150,000 төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна. | 100% |
| 3. | Тамгын газар нь жилийн ажлаа дүгнэн байгууллагын "Шилдэг ажилтан" 3 хүртэлхийг тус тус шалгаруулж, шагнаж урамшуулна. | -Гүйцэтгэлийн төлөвлөгөөний тухайн жилийн үнэлгээг харгалзана.<br>-Хамт олны хурлаар хуралдуулан шийдвэрлэнэ. | Гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас болон бүтэн жилээр үнэлүүлсэн хувь<br>Хамт олны хурлаар дэмжсэн хувь | IV улиралд | **Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй болно.** | - |
| 4. | Буцалтгүй тусламжийг төрийн албан хаагчдад байгууллагаас үзүүлнэ. | -Албан хаагч болон түүний гэр бүлийн хүн, ойр дотны хүн нас нөгчих, хүнд өвчин тусах, эмчилгээнд явах зэрэгт буцалтгүй тусламж үзүүлнэ.<br>-Цалинтай чөлөөг олгоно. | Албан хаагч болон түүний гэр бүлийн хүн, ойр дотны хүн нас нөгчих, хүнд өвчин тусах, эмчилгээнд явах зэрэгт буцалтгүй тусламж үзүүлсэн тоо<br>Цалинтай чөлөөг олгосон албан хаагчдын тоо | I-IV улиралд | 2024 он гарснаар ойр дотны хүн нь нас нөгчсөн ***2 албан хаагч*** /2-р багийн ЗД, Мэдээ мэдээлэл хариуцсан ажилтан/ нарт цалинтай чөлөө болон буцалтгүй тусламжийг үзүүлээд байна. | 100% |
| 5. | Ажилтанд тохиолдсон баярт үйл явдалд хамт олноороо хүндэтгэл үзүүлнэ. /Төрийн шагнал авах, үсний найр, байрны найр гэх мэт/ | - Албан хаагч болон түүний гэр бүлд тэмдэглэн өнгөрүүлэх баярт үйл явдалд хүндэтгэл үзүүлнэ. | Хүндэтгэл үзүүлсэн албан хаагчдын тоо | I-IV улиралд | 2024 он гарснаар 2 албан хаагч /Тамгын газрын дарга, 2-р багийн дарга/ төрийн одон шагнал болон салбарын шагнал авч, 1 албан хаагч хүүхдийн үсний найрны арга хэмжээг хийсэн. Тус 3 албан хаагчдад байгууллага хамт олноос хүндэтгэл үзүүлээд байна. | 100% |
| **Зорилт 2: Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах боломж нөхцөлөөр хангах** | | | | | | |
| 2.1 | Албан хаагчдын хэрэгцээнд тулгуурлан бичиг хэрэгсэл шаардлагатай бусад | -Байгууллагын төсөвт багтаан албан хаагчдад шаардлагатай техник хэрэгслийг шинээр авна. | Байгууллагын төсөвт багтаан албан хаагчдад шаардлагатай техник | I-IV улиралд | 2024 оны 01 дүгээр сарын 04 дүгээр сарын байдлаар байгууллагаас 1.278.400 төгрөгийн бичиг хэргийн зардал гарган ажиллаж байна. | |

Scanned with CamScanner

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | материал техник хэрэгслээр хангах ажлын байрны нөхцөлийн сайжруулах | -Албан хэрэгцээний бичиг хэргийн хэрэглэгдэхүүнээр хангасан байна. | хэрэгслийг шинээр авах<br>Албан хэрэгцээний бичиг хэргийн хэрэглэгдэхүүнээр хангах | | Төрийн байгууллагуудын шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах ажлыг 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн сумын Засаг даргын А/12 дугаар захирамжаар "Үнэлгээний хороо"-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2024 оны 2 дугаар сарын 15-ны өдөр нээлттэй тендерийг цахим сайтад зарласан. 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тендерийн нээлт хийж, үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж үзэн, "Санаа мед трейд" ХХК шалгарч гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Гэрээ хийгдсэн хугацааны дагуу 2024 оны 06 дугаар сарын 22-ны өдөр тоног төхөөрөмжийг авахаар ажиллаж байна. Ашиглагдаж буй техник тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтлийг мэргэжлийн байгууллагаар шалгуулан засварлуулах ажлыг зохион байгуулж байна. | 100% |
| 2.2 | Шинээр томилогдсон албан хаагчдыг төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлэх | -АТАСЗ-д тангараг өргөх албан хаагчдыг танилцуулж шийдүүлэх | Аймгийн Засаг даргын шийдвэрээр тангараг өргүүлсэн байна. | I-IV улиралд | 2024 оны эхний хагас жилийн байдлаар тангараг өргөсөн албан хаагч байхгүй байна. 2024 оны 10-12 дугаар сард тангараг өргөх 4 албан хаагч байна. | - |
| 2.3 | Ажлын байран дээр албан хаагчийн хувийн болон байгууллагын эд зүйлс хулгайд алдагдах, гэмт халдлагад өртөхөөс сэргийлэх | -Байгууллагын орчин тойронд камерыг суурьлуулах<br>-Илэрсэн зөрчилгүй байх<br>-Гарсан зөрчилд хариу арга хэмжээ авах | Камер суурьлуулсан тоо<br>Илэрсэн зөрчилгүй байх<br>Гарсан зөрчилд авсан арга хэмжээ | I-IV улиралд | Ажлын байран дээр албан хаагчийн хувийн болон байгууллагын эд зүйлс хулгайд алдагдах, албан хаагч гадны гэмт халдлагад өртөхөөс сэргийлэх зорилгоор 2024 оны эхний хагас жилийн байдлаар Тамгын газрын бүх байршил харагдахуйц **16** камерыг суурьлуулан ажилласан. Одоогоор гарсан зөрчил, гэмт халдлага илрээгүй байна. | 100% |

Scanned with CamScanner

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.4 | Албан хаагчдыг амь насны даатгалд хамруулах | -Амь насны даатгалд хамруулсан байх<br>-Амь насны даатгалд хамруулсан албан хаагчдыг тоо | -Амь насны даатгалд хамруулсан байх<br>-Амь насны даатгалд хамруулсан албан хаагчдыг тоо | I-IV улиралд | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэгт заагдсан "Төсвийн байгууллага нь тухайн жилийн батлагдсан төсвийн 0.5 хувиас доошгүй зардлыг ажилтны амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зарцуулах" гэсэн заалтын дагуу ***"Миг даатгал"***-д даатгуулахаар ***24 албан хаагчийн*** жагсаалтыг хүргүүлэн, амь насны даатгалд даатгуулаад байна. | 100% |
| **Зорилт 3: Орон сууцны нөхцөлөө сайжруулах орон байраар хангахад нь хөрөнгө санхүүгийн болон зохих тусламж дэмжлэг үзүүлнэ** | | | | | | |
| 3.1 | Төрийн албан хаагчийн амьдрах орчин нөхцөлөө сайжруулах орон сууц авахад зохих тусламж дэмжлэгийг байгууллагын дотоод журамд заасны дагуу үзүүлэх | -Байгууллагын ажилтан албан хаагч шинэ гэр барих шинээр орон сууцанд ороход нь дотоод журмын дагуу дэмжлэг үзүүлэх<br>-Орон сууцны хөнгөлөлтэй зээлэнд хамрагдахад мөрдөгдөж байгаа журмын дагуу дэмжлэг үзүүлнэ | Санхүүгийн дэмжлэг үзүүлсэн байна. | I-IV улиралд | 2024 оны эхний хагас жилийн байдлаар шинээр гэр барих, шинээр орон сууцанд орсон, орон сууцны хөнгөлөлтэй зээлэнд хамрагдах хүсэлтэй албан хаагч байхгүй байна. | - |
| 3.2 | Шинээр шилжин ирсэн албан хаагчдыг орон сууцаар хангах | -Шинээр ирсэн албан хаагчдыг орон сууцаар хангах<br>-Байгууллагын орон сууцыг албан хаагчдад түрээслүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх | Шинээр ирсэн албан хаагчдыг орон сууцаар хանган ажилласан байна.<br>Байгууллагын орон сууцыг албан хаагчдад түрээслүүлсэн тоо | I-IV улиралд | 2024 он гарснаар 1 албан хаагч байгууллагын орон сууцанд сарын 32.900 төгрөгийн "Түрээсийн гэрээ" байгуулан, 2023 оны 10 дугаар сараас 2024 оны 4 сар хүртэл амьдран суусан. Бусад албан хаагчид өөрсдийн хувийн өмчлөлийн сууцанд амьдарч байна. | 100% |
| 3.3 | Төрийн албан хаагчдын амьдрах орчин нөхцөлийг дэмжих | - Төрин албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ ажлын төсвийг батлуулах<br>- Тухайн онд багтаан ажлын гүйцэтгүүлсэн байна. | Төрин албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/ ажлын төсвийг батлуулах<br>Ажлын гүйцэтгэл | I-IV улиралд | 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ИТХ-ын 06 дугаар тогтоолоор ***Төрин албан хаагчдын амьдрах орчин нөхцлийг дэмжих /байр засварлах/*** ажлын төсвийг 276,500,000 төгрөгөөр баталсан. Сумын Засаг даргын 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн А/17 | 70% |

Scanned with CamScanner

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаар захирамжаар "Үнэлгээний хороо"-г 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Нээлттэй тендерийг цахим сайтад 3 удаа зарлаж, 05 дугаар сарын 09-ний өдөр үнэлгээний хороогоор ирүүлсэн материалыг хянаж үзэхэд оролцогч оролцоогүй тул 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр тендерийг дахин зарлаад байна. | |
| **Зорилт 4: Эрүүл мэндийн үйлчилгээ хүртээмж сайжруулах** | | | | | | |
| 4.1 | Идэвхитэй хөдөлгөөн биеийн тамирын уралдаан тэмцээн бэлтгэл сургуулилтыг олон хэлбэрээр зохион байгуулах | -Байгуулагын албан хаагчдыг биеийн тамир спортын уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлэх<br>-Уралдаан тэмцээнд оролцоход хувцас болон бусад шаардлагатай зүйлсээр хангах | Албан хаагчдыг 100% хамруулсан байна Шаардлагатай албан хаагчдад чөлөө олгох санхүүгийн болон материаллын тусламж үзүүлсэн байна. | I-IV улиралд | Биеийн тамир, урлаг спорт, дасгал хөдөлгөөнийг хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд эхний хагас жилийн байдлаар:<br>➢ 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдсан "Өвлийн агаар-Өлчир бие" арга хэмжээнд бүх албан хаагч оролцсон.<br>➢ Аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан 3 төрөлт спортын бага наадамд сумын төсвийн байгууллагуудтай ***хамтран оролцсон***.<br>➢ "Нөхөрлөл-2024" спортын 3 төрөлт бага наадамд сумын үе үеийн төлөөллийн ***100 гаруй төгсөгч*** оролцсон бөгөөд төгсөгчдийн дунд байгууллагын 5 албан хаагч оролцсон.<br>➢ 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдөр сумын Соёлын төвөөс зохион байгуулагдсан "Урлагийн үзлэг"-ийн 3 | 100% |

Scanned with CamScanner

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төрөлд 11 албан хаагч оролцоод байна. | |
| 4.2 | Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах | -Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах<br>-Шаардлагатай тохиолдолд эмчлүүлэх нөхцөл боломжоор хангаж дотоод журамд заасны дагуу тусламж дэмжлэг үзүүлэх | Албан хаагчдыг хагас болон бүтэн жилээр эрт илрүүлэг үзлэгт хамруулах | II-IV улиралд | Хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг шинжилгээ, оношилгоонд жил бүр албан хаагчдаа хамруулдаг бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр сумын Эрүүл мэндийн төвд 13 албан хаагчийг хамруулаад байна. Шинжилгээний хүрээнд онц ноцтой өвчин илрээгүй болович ходоодны хеликобактерийн дамжилт илэрсэн тул III улиралд багтаан бүх албан хаагчдыг эмчилгээнд оруулахаар ажиллаж байна. | 100% |
| **Зорилт 5: Амралт чөлөө цагийг зөв боловсон өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах** | | | | | | |
| 5.1 | Нийтийг хамарсан тэмдэглэлт өдөр баярыг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх | -Шинэ жил, цагаан сар, наадам болон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Эр цэргийн баяр, Эх үрсийн баяр, Ахмадын баярыг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах<br>-Төрсөн өдөр нь тохиож байгаа ажилтан хаагчдад баяр хүргэж дурсгалын зүйл гардуулах | Арга хэмжээ зохион байгуулах<br>Нийт албан хаагчдыг бүрэн хамруулсан байна. | I-IV улиралд | 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хамт олны хурлаар байгууллагын “Хамт олны зөвлөл”-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон. Тус зөвлөл нь бүх нийтийг хамарсан тэмдэглэлт өдөр, баяр ёслолууд зэрэг дотоод ажлыг хариуцан зохион байгуулдаг бөгөөд 2024 он гарснаар:<br>• Уламжлалт Сар шинийн баяр<br>• Олон улсын Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр<br>• Эр цэргийн баяр<br>• Эх үрсийн баяр зэргийг тэмдэглэн өнгөрүүлээд байна. | 100% |
| 5.2 | Байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэн, арга хэмжээнүүдийг | -Дээрх арга хэмжээнүүдэд “Эцэг эхийн зөвлөл” хамтран оролцох<br>-Тэмдэглэлт баяр ёслолоор албан хаагчдын хүүхдүүдэд | Арга хэмжээ зохион байгуулах<br>Нийт албан хаагчдын | I-IV улиралд | 2024 он гарснаар байгууллагын “Эцэг эхийн зөвлөл”-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэхээр байгууллагын “Хамт олны зөвлөл” нар хамтран 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр албан хаагчдын 30 орчим хүүхдэд Эх үрсийн баярыг | 100% |

Scanned with CamScanner

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | хамтран зохион байгуулах | зориулсан арга хэмжээг зохион байгуулах | хүүхдүүдийг бүрэн хамруулсан байх | | уггсан арга хэмжээг зохион байгуулан, гарын бэлэг гардуулаад байна. | |
| 5.3 | Байгалийн үзэсгэлэнт газраар аялах, амралт зохион байгуулах | - Зуны амралтыг зохион байгуулж хамт олноо бүрэн хамруулах | Байгалийн үзэсгэлэнт 1-с доошгүй газраар аялсан байна. | III улиралд | **Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй болно.** | - |
| 5.4 | Байгууллага хамт олноороо нийтийг хамарсан бүтээлч арга хэмжээнд оролцох | -Бүх нийтээр мод тарих хүрээнд байгууллагын эзэмшлийн газар, нийтийн эдэлбэр газарт мод тарих<br>-Олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах | Бүх нийтээр мод тарих хүрээнд байгууллагын эзэмшлийн газар, нийтийн эдэлбэр газарт мод тарих | I-IV улиралд | Тэрбум үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын дагуу 2024 оны хаврын мод, бут тариалалт 5 дугаар сарын 17-оос эхэлсэн бөгөөд эхний байдлаар 110ш шар хуайсыг байгууллагаас тариад байна. /Албан хаагч бүр 5ш мод/ | 100% |
| **Зорилт 6: Төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх** | | | | | | |
| 6.1 | Байгууллагын албан хаагчдыг танхимын болон цахим сургалтад хамруулах | -Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөний тоо<br>-Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо | Зохион байгуулсан сургалт, зөвлөгөөний тоо<br>Хамрагдсан төрийн албан хаагчдын тоо | I-IV улиралд | Аймаг орон нутаг болон холбогдох мэргэжлийн байгууллагаас танхимын болон цахим сургалт 15 удаа явуулж давхардсан тоогоор 150 албан хаагч хамрагдсан. | 100% |
| 6.2 | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэхээр ёс зүйн сургалтыг зохион байгуулах | -Зохион байгуулсан сургалтын тоо<br>-Хамрагдсан албан хаагчдын тоо | Зохион байгуулсан сургалтын тоо<br>Хамрагдсан албан хаагчдын тоо | I-IV улиралд | 2024 оны "Дотоод эрх зүйн сургалт"-ын төлөвлөгөөг ***14 арга хэмжээтэйгээр төлөвлөж,*** төлөвлөгөөний дагуу 2024 оны 03 дугаар сард Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага сэдвээр аймгийн Шүүхийн Тамгын газрын даргаас сургалт авч, 13 албан хаагч хамрагдсан. | 100% |
| 6.3 | Төрийн албан хаагчдыг Угийн бичгийн сургалтад хамруулах | -Зохион байгуулсан сургалтын тоо<br>-Хамрагдсан албан хаагчдын тоо | Зохион байгуулсан сургалтын тоо<br>Хамрагдсан албан хаагчдын тоо | I-IV улиралд | Угийн бичиг хөтлөх анхан шатны сургалтанд албан хаагчдыг хамруулах ажлын хүрээнд 2024 он гарснаар сумын Угийн бичгийн сургагч багшаар "Угийн бичиг хөтлөх, хөтлөхийн ашиг тус, угийн бичгийн зурган тэмдэглэгээ"-ний талаар анхан шатны сургалтыг ЗДТГ, | 100% |

Scanned with CamScanner

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ИТХ, Соёлын төвийн ажилчидтай хамт нийт 30 албан хаагчид 2024 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр хамрагдаад байна. | |
| Дундаж биелэлт | | | | | | 98.2 |

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН МЭРГЭЖИЛТЭН М.ГАНТУЯА

ХЯНАСАН:

ЗДТГ-ЫН ДАРГА Д.ОТГОНЖАРГАЛ

УСА0004 9018441

Scanned with CamScanner